

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

**ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХЭЛТСИЙН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН  
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ  
ДАДАРМАРАВЫН БУЯНЖАРГАЛЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
1	2	3	4	5	6	7		
<b>Зорилт 1. “Зорилтот өрх, иргэдийн хэрэгцээ, шаардлагад үндэслэсэн 3-аас доошгүй үйлчилгээг шинээр үзүүлнэ.”</b>								
1.	<b>Арга хэмжээ 1.1.</b> Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.	100%	30%	70%	“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.” гэж заасан. Энэхүү бодлогын зорилттой уялдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.11.27-ны өдрийн “Ажлын хэсэгт байгуулах тухай” А/58 дугаар тушаалаар байгуулан, Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул ахлан, судалгааны дэд ажлын хэсэгт судлаач, багш, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан ажиллаж байна.  Нийгмийн халамжийн тухай хуулийн үзэл баримтлалыг 2024.12.20-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамtran баталсан.	01-06		

				<p>Хуулийн хэлэлцүүлгийг төрийн болон төрийн бус байгууллагыг оролцуулан танхимаар болон цахимаар зохион байгууллаа.</p> <p>Мөн хуулийн төсөлд иргэд олон нийтээс санал авахаар 2025.04.16-ны өдөр яамны цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Хэлэлцүүлгийн саналыг тусган хуулийн төслийг эцэслэн боловсруулж, товч танилцуулга, тандан судалгаа, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээний хамт 2025.05.06-ны өдрийн “Санал авах тухай” 01/1454 дүгээр албан бичгээр Засгийн газрын гишүүдэд санал авахаар хүргүүлсэн.</p> <p>Яамдын Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөхөөр ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд 2025.05.23-ны өдөр хуулийн төслийн үндсэн агуулгыг танилцуулан, мэдээлэл өгөх, санал солилцох хэлэлцүүлгийг зохион байгууллаа.</p> <p>Яамдаас ирүүлсэн саналыг тусган хуулийн төслийг сайжруулан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2025.06.06-ны өдрийн 01/1884 дугаар албан бичгээр Сангийн яамнаас, мөн өдрийн 01/1881 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар хүргүүлсэн.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2025.06.12-ны өдрийн 1/3209 дүгээр албан бичгээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл ирүүлсэн.</p> <p>Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийн иж</p>	
--	--	--	--	--	--

					бүрдлийг ханган Засгийн газар болон Улсын Их хуралд өргөн мэдүүлэхээр бэлэн болсон.		
<b>Дэд арга хэмжээ – 1.1.1:</b> Хуулийн төслийг шинэчлэн боловсруулна.	100%	30%	70%	Нийгмийн халамжийн тухай хуулийн үзэл баримтлалыг 2024.12.20-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан.	Хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн, хэлэлцүүлгээс гарсан санал болон яамдаас ирүүлсэн саналыг тусган хуулийн төслийг эцэслэн боловсрууллаа.	Хуулийн төслийг боловсруулахдаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Орхон аймгийн ХХҮГ, Чингэлтэй дүүргийн ХХҮХ-ийн холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан саналыг тусган, хамтран боловсруулсан.	01-06
<b>Дэд арга хэмжээ – 1.1.2:</b> Зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээ болон				Хуулийн төслийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн бүх албан хаагчдад танилцуулж хэлэлцүүлэн, саналыг нэгтгэн 2025.05.29-ний өдрийн 01/911 дүгээр албан бичгээр ирүүлсэн.	Ирүүлсэн саналыг тусган Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс холбогдох байгууллагуудад танилцуулах арга хэмжээг зохион байгуулж, Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналыг тусган эцэслэн боловсруулсан.	Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийн иж бүрдлийг ханган Засгийн газрын хуралдаанд өргөн мэдүүлэхээр бэлэн болсон.	01-06

	бусад холбогдох баримт бичгийг боловсруулна.	100%	30%	70%	<p>баримт, бодлогын зөвлөмж, судалгааны тайлангуудад үндэслэн боловсрууллаа.</p> <p>Мөн хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг Засгийн газар, Улсын Их Хуралд өргөн мэдүүлхэдэ шаардлагатай дараах баримт бичгийг боловсруулсан:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хуулийн төслийн үзэл баримтлал;</li> <li>2. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын;</li> <li>3. Дагалдах 18 хуулийн төсөл;</li> <li>4. Хуулийн төслийн товч танилцуулга</li> <li>5. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга;</li> <li>6. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа;</li> <li>7. Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ;</li> <li>8. Хуулийн төсөл хэрэгжүүлэхтэй холбогdon гарах зардлын тооцоо;</li> <li>9. Хэлэлцүүлгийн тайлан /Олон нийт, холбогдох бусад байгууллага, иргэд/;</li> <li>10. Бодлогын зөвлөмжийн нэгтгэл болон хуулийн төслийн хэлэлцүүлэгт шаардлагатай бусад материал.</li> </ol> <p>Баримт бичгийг Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад баримт бичигт заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж бэлтгэлээ.</p>	
	Дэд арга хэмжээ – 1.1.3: Хуулийн төслийг оролцогч талуудад хэлэлцүүлэн санал авч тусгана.	100%	30%	70%	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, дараах байдлаар хэлэлцүүллээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ 2025.01.16-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.11.27-ны өдрийн А/58 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан хэлэлцүүлэв.</li> <li>✓ 2025.01.22-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуулийг боловсруулах судалгааны дэд</li> </ul>	01-06

				<p>ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан хэлэлцүүлэв.</p> <p>✓ 2025.01.29-ний өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, тэдгээрийн төлөөлөл /цахимаар 96, танхимаар 16/-д танилцуулан хэлэлцүүлэв.</p> <p>✓ 2025.01.29-ний өдөр аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хэлтсийн Нийгмийн халамжийн хэлтэс, албадын дарга нар /30 хүн/-т цахимаар танилцуулан хэлэлцүүлэв.</p> <p>✓ 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудын төлөөлөл /25 хүн/-д танилцуулан хэлэлцүүлэв.</p> <p>✓ 2025.02.05-07-ны өдрүүдэд ХХҮЕГ, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын мэргэжилтнүүдтэй хамtran Нийгмийн халамжийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах саналыг хэлэлцүүлэв.</p> <p>✓ 2025.05.09-ний өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ-үүд /ЭМЯ, НДЕГ, ХБХХЕГ, ХХҮЕГ, ТББ-үүд/-д танилцуулан санал авч, хэлэлцүүллээ.</p> <p>✓ 2025.05.23-ны өдөр яамдын Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөхөөр ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд мэдээлэл өгөх, санал солилцох хэлэлцүүлгийг зохион байгууллаа.</p> <p>✓ 2025.06.03-ны өдөр Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, төрийн бус байгууллага, холбоодод Нийгмийн халамжийн тухай хуулийн</p>	
--	--	--	--	--	--

					шинэчилсэн найруулгын төслийг танилцуулан танилцуулан санал авч, хэлэлцүүллээ.  Хуулийн төслийг УИХ-ын дарга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Төрийн нарийн бичгийн дарга, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд, тус байнгын хорооны албан хаагчдад танилцуулах уулзалтыг нийт 10 гаруй удаа зохион байгуулсан. Мөн яамны холбогдох газар хэлтсийн дарга болон, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс холбогдох байгууллагуудад танилцуулах арга хэмжээг мөн нийт 10 гаруй удаа зохион байгуулсан.  Олон нийтээс санал авах зорилгоор тус яамны цахим хуудсанд 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төслийг байршуулсан. Түүнчлэн цахимаар, утсаар, биечлэн ирүүлсэн саналуудыг судлан үзэж хуулийн төсөлд тусгалаа.	
2.	<b>Арга хэмжээ 1.2</b> Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	100%	0%	100%	Хуулийн төслийг эцэслэн боловсруулж, товч танилцуулга, тандан судалгаа, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээний хамт 2025.05.06-ны өдрийн "Санал авах тухай" 01/1454 дүгээр албан бичгээр Засгийн газрын гишүүдэд санал авахаар хүргүүлсэн.  Дээрх албан бичгийн хүрээнд санал ирүүлсэн 16 яамны саналыг тусган хуулийн төслийг сайжруулан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2025.06.06-ны өдрийн 01/1884 дугаар албан бичгээр Сангийн яамнаас, мөн өдрийн 01/1881 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар хүргүүлсэн.	01-06

					Xууль зүй, дотоод хэргийн яамнаас 2025.06.12-ны өдрийн 1/3209 дүгээр албан бичгээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл ирүүлсэн.  Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийн иж бүрдлийг ханган Засгийн газрын хуралдаанд өргөн мэдүүлэхээр бэлтгэсэн.		
3.	<b>Арга хэмжээ 1.3</b> Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг Улсын Их хуралд өргөн мэдүүлнэ.	100%	0%	100%	Яамдаас ирүүлсэн саналыг тусган хуулийн төслийг сайжруулан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.7, 20.8-д заасны дагуу 2025.06.06-ны өдрийн 01/1883 дугаар албан бичгээр Сангийн яамнаас, мөн өдрийн 01/1882 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл авахаар хүргүүлсэн.  Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийн иж бүрдлийг ханган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлэн болсон.	01-06	
4.	<b>Арга хэмжээ 1.4.</b> "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулна.	100%	0%	100%	Засгийн газрын 2021 оны 362 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам"-ыг хэрэгжүүлэх явцад гарсан тодорхой тусгах шаардлагатай зарим асуудал, үйлчилгээг хүргэх процессыг хялбарчлах хэрэгцээ шаардлагад үндэслэн "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулав.  Журмын төслийг боловсруулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлэн, аймаг дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс санал авч саналыг	01-06	

					<p>тусган эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>Журмын төсөлд нэг гэр бүлийн бүтэн өнчин хүүхдийг гэр бүлдээ авч асарч байгаа тохиолдолд хүүхдийн тоо хязгаарлахгүй байх, төрөлжсөн асрамжийн газарт асуулж байгаа тэжээгч нас барсан хүүхдийг халамжийн тэтгэвэрт хамруулах, тэтгэврийг банканд хадгалах, насанд хүрэх эсхүл асрамжаас гарахад тэтгэврийн мөнгийг хүлээлгэн өгөх, хяналт тавих зохицуулалтыг тусгах, тэтгэвэр, тэтгэмжийн мөнгийг барьцаалж зээл авах, олгох, банкны зээлд суутгахыг хориглох, хяналт, шинжилгээ, үнэлгээ, хариуцлагын заалт болон иргэдийн санал гомдлыг нээлттэй хүлээн авч шийдвэрлэх зэрэг зохицуулалтыг нэмж тусгасан.</p> <p>Засгийн газрын 2024 оны 247 дугаар тогтоолын хүрээнд Байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд үүнтэй холбогдуулан тэтгэмжид хамруулах хүүхдийн тооцоо судалгааг хийж ажилласан.</p> <p>Журмын нэмэлт өөрчлөлтийг 2025 оны сүүлийн хагас жилд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулна.</p>		
5.	Арга хэмжээ 1.5. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх	100%	0%	100%	<p>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 247 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 22.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн сард олгох хэмжээг 397500 төгрөгөөр, байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмжийн хэмжээг 142.5 мянган төгрөгөөр</p>	01-06	

					<p>нэмэгдүүлэн сард олгох хэмжээг 445.0 мянган төгрөг байхаар тус тус тогтоон мөрдөж байна.</p> <p>Уг тогтоолын хүрээнд Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн “Тушаалд нэмэлт оруулах тухай” А/68, А/62 дугаар тушаалаар “Байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох өвчин, гэмтлийн жагсаалт, шалгур”-ыг баталсан. Уг тушаалын дагуу аймаг, дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комиссууд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлж байгаа бөгөөд халамжийн нэгдсэн системд нийгмийн халамжийн тэтгэвэр болон асаргааны тэтгэмжийг нэмэгдүүлсэн дүнгээр олгох зохих хөгжүүлэлтийг хийж, асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн олгож байна.</p> <p>2025 оны эхний 5 сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэрт 59.0 мянган иргэн хамрагдаж, нийгмийн халамжийн сангаас 114.9 тэрбум төгрөгийг олгосон байна.</p> <p>Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 2026 онд мөн 6 хувиар нэмэгдүүлэхээр төсвийн тооцооллыг боловсруулан 2026 оны Төсвийн хязгаарын саналд тусган ажиллаж байна.</p>		
6.	Арга хэмжээ 1.6. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд судалж, шийдвэрлэнэ.	100%	00%	100%	2025 оны эхний хагас жилд иргэдээс ирүүлсэн 15 өргөдлийг шийдвэрлэн хариу хүргүүлсэн. Мөн холбогдох байгууллагаас албан бичгээр, утсаар, цахимаар ирүүлсэн албан бичиг, санал хүсэлт зэрэгт хариулт өгч ажилласан.	01-06	

7.	<p><b>Арга хэмжээ 1.7.</b> Мэдээ, тайланг хуулийн хугацаанд холбогдох нэгж, байгууллагад хүргүүлнэ.</p>	100%	0%	100%	<p>2025 онд Нийгмийн халамжийн хэлтсийн сарын тайланг 3 удаа, 7 хоногийн тайлан төлөвлөгөөг 12 удаа нэгтгэн, нэгжийн даргад танилцуулсан. Сар, улирал, хагас жилийн мэдээ, тайланг нэгтгэх, өөрийн хариуцах асуудлын хүрээнд тайлагнах зэрэг ажлыг цаг хугацаанд нь бүрэн хийж гүйцэтгэлээ. Тухайлбал,</p> <p>1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 218 дугаар тогтооолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилт;</p> <p>2. Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтооолоор батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилт;</p> <p>3. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтооолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт;</p> <p>4. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар албан даалгаврын хэрэгжилт.</p> <p>5. ГБХНХЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт</p> <p>6. Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт</p> <p>7. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн биелэлт гэх мэт.</p>	01-06	
8.	<p><b>Арга хэмжээ 1.8.</b> Газар, хэлтсээс зохион байгуулсан дараах сургалт, арга хэмжээнд тухай бүр оролцно.</p>	100%	0%	100%	<p>Газар, хэлтсээс зохион байгуулсан дараах сургалт, арга хэмжээнд тухай бүр оролцлоо.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах сургалт</li> <li>✓ Зөвлөн ур чадвар сургалт</li> <li>✓ Илтгэх урлагийн сургалт</li> <li>✓ Харилцааны таван зарчим сургалт</li> </ul>	01-06	

				<ul style="list-style-type: none"> <li>✓ Ажлын байрны стрессийг бууруулах өнгөний сэтгэл зүй сургалт</li> <li>✓ Хиймэл оюуны шилжилт</li> </ul> <p>Байгууллагаас зохион байгуулсан эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдаж, спорт өдөрлөг, сургалтад оролцсон.</p> <p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний санал боловсруулах, ГБХНХЯ-ны 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг, Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгүүдэд орж ажиллалаа.</p>	
--	--	--	--	--	--

#### Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)				
1	2	3	4	5	6	7			
1.	<b>Арга хэмжээ 1.</b> Нийгмийн халамжийн чиглэлээр бусад оронд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийгдэж байсан судалгааг уншиж судлана.	100%	0%	100%	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд Хуулийн төслийг боловсруулах техникийн ажлын хэсгээр хуралдаж, бичвэрийг сайжруулан ажиллаж байна. Мөн Эстони, Япон, Филиппин, БНСУ гэх мэт олон улсын нийгмийн халамжийн хуулийг судлав. Мөн Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хүрээнд дараах бодлогын зөвлөмж, судалгааны материалыг уншиж танилцав: <ul style="list-style-type: none"> <li>✓ Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн дизайн, үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ, Эрдэм партнерс, 2018 он</li> <li>✓ “Нийгмийн хамгааллын тогтолцооны концепци загвар боловсруулах судалгааны тайлан” ТУС солюшн, 2024 он</li> </ul>	01-06			

					<ul style="list-style-type: none"> <li>✓ "Нийгмийн халамжийн өнөөгийн байдал, цаашдын зорилт" бодлогын зөвлөмж, ГБХНХЯ, 2024 он</li> <li>✓ "Монгол Улсын төсвийн судалгаа"-Дэлхийн банк, 2025 он</li> </ul>			
2.	<p><b>Арга хэмжээ 2.</b> Хариуцсан асуудлын чиглэлээр зохих сургалтанд хамрагдана.</p>	100%	0%	100%	<p>Тайландын Хаант Улсын Бангкок хотноо Нэгдсэн үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Ази Номхон Далайн бүсийн төвөөс 2025.02.11-13-ны өдрүүдэд зохион байгуулсан "Ази Номхон далайн бүс нутгийн Нийгмийн хамгаалал ба дасан зохицох чадавх" сэдэвт олон улсын семинарт оролцлоо. Семинарт Ази Номхон Далайн бүсийн Монгол, Камбож, Шриланк, Пакистан, Афганистан, Филиппин, Непал, Вьетнам, Бангладеш, Зүүн Тимор зэрэг улсын Нэгдсэн үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын ажилтнууд болон улсын нийгмийн хамгааллын байгууллагын төлөөллүүд оролцлоо.</p> <p>Мөн хариуцсан асуудлыг чиглэлээр дараах сургалт, уулзалт, хэлэлцүүлэгт оролцлоо.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ ГБХНХЯ-ны зөвлөх Н.Аюушийн "Хууль тогтоомжийн төслийг боловсруулахад анхаарах асуудал" сургалт;</li> <li>✓ Дэлхийн банкны "Монгол Улсын төсвийн судалгаа"-ны тайлан хэлэлцүүлэг;</li> <li>✓ ЖАЙКА ОУБ-ын "Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл" -ийн хүрээнд зохион байгуулагдсан Ажилд ороход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2 болон 3 дахь удаагийн семинар;</li> <li>✓ "Үндэсний тодорхойлсон хувь нэмрийг шинэчлэн тодорхойлох хэлэлцүүлэг-нийгмийн хамгааллын салбар" сэдэвт хэлэлцүүлэг;</li> </ul>	01-06		

					<ul style="list-style-type: none"> <li>✓ ХХААХҮЯ-аас зохион байгуулсан "Хүнсний баталгаат бус байдлын эрсдлийн хариу арга хэмжээний удирдлагыг сайжруулах удирдамж"-ийн төслийг хэлэлцэх хэлэлцүүлэг;</li> <li>✓ "Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн байдал" үндэсний зургаадугаар судалгааны тайлан, хэлэлцүүлэг гэх мэт.</li> </ul>		
--	--	--	--	--	---	--	--

**Тайлан гаргасан:**

Нийгмийн халамжийн хууль тогтоомж,  
тэтгэвэр, тэтгэмжийн бодлого,  
төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч

..... / Д.Буянжаргал/

2025.06.....

**Хянан баталгаажуулсан:**

Хөдөлмөрийн бодлогын газрын  
Нийгмийн халамжийн хэлтсийн  
дарга

..... /Ю.Отгонбилэг/

2025.06.....

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
5 дугаар хавсралт

### НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС (ЗАГВАР)

#### Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)

Д/д	Үүрэг даалгавар	Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1.	<b>Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.</b> Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллав.	Хөдөлмөрийн бодлогын газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга Ю.Огтонбилэг	Хуулийн төслийн зохих зүйлийг боловсруулсан байх	0	Хуулийн төслийн зохих зүйлийг боловсруулсан.	2025.03	2025.04

#### НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:

Нийгмийн халамжийн тэтгэвэр,  
тэтгэмжийн бодлого, төлөвлөлт,  
хариуцсан ахлах шинжээч  
( Албан тушаал )

..... / Д.Буянжаргал/

( Нэр, гарын үсэг )

( Огноо )

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**  
Хөдөлмөрийн бодлогын газрын  
Нийгмийн халамжийн хэлтсийн  
дарга

( Албан тушаал )

Ю.Огтонбилэг/

( Нэр, гарын үсэг )

( Огноо )

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
8 дугаар хаесралт

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯМНЫХӨДӨЛМӨРИЙН  
БОДЛОГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХЭЛТСИЙН НИЙГМИЙН  
ХАЛАМЖИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ ДАДАРМАРАВЫН  
БУЯНЖАРГАЛЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР  
ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС  
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам  
Нэгжийн нэр: Хөдөлмөрийн бодлогын газар, Нийгмийн халамжийн хэлтэс

#### 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
					1
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	

Зорилт 1. ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯМНЫ 2025 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ “Зорилтот өрх, иргэдийн хэрэгцээ, шаардлагад үндэслэсэн  
3-аас доошгүй үйлчилгээг шинээр үзүүлнэ.”

1.	Арга хэмжээ 1.1. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.	60	10	70	70
	Дэд арга хэмжээ – 1.1.1: Хуулийн төслийг шинэчлэн боловсруулна.	60	10	70	70
	Дэд арга хэмжээ – 1.1.2: Зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээ болон бусад холбогдох баримт бичгийг боловсруулна.	60	10	70	70
	Дэд арга хэмжээ – 1.1.3: Хуулийн төслийг оролцогч талуудад хэлэлцүүлэн санал авч тусгана.	60	10	70	70
2.	Арга хэмжээ 1.2 Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	50	10	60	60
3.	Арга хэмжээ 1.3 Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг Улсын Их хуралд өргөн мэдүүлнэ.	50	10	60	60
4.	Арга хэмжээ 1.4. “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг	50	10	60	60

	боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулна.				
5.	Арга хэмжээ 1.5. Нийгмийн хalamжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх	60	10	70	70
6.	Арга хэмжээ 1.6. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд судалж, шийдвэрлэнэ.	60	10	70	70
7.	Арга хэмжээ 1.7. Мэдээ, тайланг хуулийн хугацаанд холбогдох нэгж, байгууллагад хүргүүлнэ.	60	10	70	70
8.	Арга хэмжээ 1.8. Газар, хэлтсээс зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд тухай бүр оролцно.	60	10	70	70
<b>Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт</b>					
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Гэр булийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллав.	60	10	70	70
Дундаж оноо:			67,5	67,5	

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
				1
1.	Арга хэмжээ 1. Нийгмийн хalamжийн чиглэлээр бусад оронд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийгдэж байсан судалгааг уншиж судлах	93	14	14
2.	Арга хэмжээ 2. Хариуцсан асуудлын чиглэлээр зохих сургалтанд хамрагдах	93	14	14
Дундаж оноо			14	14

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
			1
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	7	7
3.	Асуудал шийдвэрлэх	7	7
4.	Хариуцлагатай байдал	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	7	7
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	7	7
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	7	7
Дундаж оноо		7	7

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)**

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 ондоо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
	<b>Дундаж оноо</b>	<b>8</b>

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлтт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	67,5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ )	7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
	<b>Нийт оноо =</b> (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ) ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо	96,5

**Үнэлгээ өгсөн: Нэгжийн дарга**

Нийгмийн халамжийн  
хэлтсийн дарга  
(албан тушаал)

(гарын үсэг)

/Ю.Отгонбилэг/  
(албан хаагчийн нэр)

2025.06.13. (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,  
зөвшөөрсөн:**

**Төрийн жинхэнэ албан хаагч:**

Нийгмийн халамжийн хууль тогтоомж,  
тэтгэвэр, тэтгэмжийн бодлого, төлөвлөлт  
хариуцсан ахлах шинжээч  
(албан тушаал)

(гарын үсэг)


/Д.Буянжаргал/  
(албан хаагчийн нэр)

2025.06.13.

**Үнэлгээг хянасан:**

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

(албан тушаал)

  
(гарын үсэг)

И. В. Чубинширов  
(албан хаагчийн нэр)

2025.06.20

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Яамны хүний нөөцийн асуудал хариуцсан шинжээч  
(албан тушаал)

  
(гарын үсэг)


Б. Баянжаргал  
(албан хаагчийн нэр)

2025.06.20

**Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч**

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
(албан тушаал)



  
Л. МӨНХЗУЛ  
(Удирдлагын нэр)

2025.06.20